

## ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Дотоод хяналт шалгалтын нэр:

Төвийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт  
тавих, ажлын үр дүнг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх  
шаардлагатай зөвлөмж өгөх

Хамрагдсан байгууллага:

Үндэсний Дата төв УТҮГ

Улаанбаатар хот

2025 он

## ТАНИЛЦУУЛГА

Үндэсний дата төв нь Монгол Улсад цахим засаглалыг хөгжүүлэх зорилго бүхий Цахим Монгол, Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 183 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэг бүхий улсын төсөвт үйлдвэрийн газар юм.

### **БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ:**

Тус төв нь эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- ✓ Төрийн цахим мэдээлэл, өгөгдлийн сан, мэдээллийн технологийг зориулалтын нөхцөлд хадгалах, хүртээмжтэй байлгах, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг хангах;
- ✓ Төрийн цахим мэдээлэл, өгөгдлийн сангуудын нэгдмэл байдал, уялдаа холбоог хангах;
- ✓ Төрийн байгууллагуудад мэдээллийн технологи, өгөгдлийн боловсруулалтын талаар мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах;
- ✓ Иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон бусад байгууллагуудыг хуулиар хориглоогүй мэдээллийн үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлэх;
- ✓ Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэх, сургалт явуулах;
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын будилаан /incident/ -аас урьдчилан сэргийлэх, кибер халдлага, довтолгооны эсрэг хариу арга хэмжээ авахад нь "Үндэсний дата төв" УТҮГ-аас үйлчилгээ авдаг иргэд аж ахуйн нэгж, төрийн болон бусад байгууллагуудад тусламж, дэмжлэг үзүүлэх;
- ✓ Интернэтийн дотоод харилцан холболтын ашиглалт үйлчилгээг хариуцах, харилцан холболтын төхөөрөмжөөр дамжиж буй халдлага, будилааны талаар анхааруулга өгөх;
- ✓ Контентын харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх;

### **Байгууллагын бүтэц:**





Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 183 дугаар тогтоолоор анх Үндэсний дата төв улсын төсөвт үлдвэрийн газрыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын дэргэд байгуулагдсан.

2024 оны 07 дүгээр сарын 30-ны өдрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдын А/04 тоот тушаал "Үндэсний Дата төв" УТҮГ-ын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн баталсан.

Тус байгууллага нь 5332304 улсын бүртгэлийн дугаартай, Төрийн сан банканд 1 харилцах данстай үйл ажиллагаагаа явуулсан байна.

Дотоод, хяналт шалгалтын хамрах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг тус газрын дарга М.Баттулга, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Д.Сэлэнгэ томилогдон тус тус гарын үсэг зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

## **ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ**

### **Дотоод хяналт шалгалт хийх үндэслэл, бүрэлдэхүүн:**

Үндэсний Дата төвийн 2025 оны 02 дүгээр сарын 12-ны өдрийн баталсан А/21 тоот удирдамжийн дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлт, урсгал худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилтийг ЗУГ-ын дарга Х.Төрийнжавхлан, ЗУГ-ын ахлах мэргэжилтэн С.Урангуа, ХҮХ-ийн дарга Ж.Нямгэрэл, ЗУГ-ын хуульч Г.Анар, ЗУГ-ын нярав Г.Ундраа нар 2025 оны 02 дүгээр сарын 17-ний өдрөөс 03 дугаар сарын 07-ны өдрийн хооронд шалгалт хийв.

### **Зорилго:**

Байгууллагын албан хэрэг хөтлөлт, урсгал худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангахад оршино.

### **Хамрах хүрээ:**

Дотоод хяналт шалгалтад тус байгууллагын 2024 оны үйл ажиллагаа хамрагдана.

### **Хяналт шалгалт:**

Хяналт шалгалтад дараах үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Удирдлагын А. Б тушаал;
- Урсгал худалдан авалт, гэрээ, хэлцэл нь хууль эрх зүйн үндэслэлтэй хийгдсэн эсэх, тэдгээрийн хэрэгжилт;
- Байгууллагын төлөвлөгөө, тайлангийн хэрэгжилт;

Дотоод хяналт шалгалтыг үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл явцыг үнэлэх, санхүүгийн тайлангууд, анхан шатны баримтуудыг хамруулан явуулж, лавлагаа, тодруулга авах зэрэг хяналт шалгалтын горимын дагуу нотлох баримт цуглуулан гүйцэтгэж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

### **Өмнөх шалгалтаар**

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/39 дугаартай тушаалаар баталсан удирдамжийн дагуу Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газарт төлөвлөгөөт хяналт шалгалт хийж дүгнэлт, зөвлөмж гарсан. Энэхүү зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хэрэгжүүлэн ажилласан байна.



Төв нь тодорхой төхөөрөмж лицензүүд хэрэглэдэг олон улсын ISO гэрчилгээтэй, онцлог үйл ажиллагаатай хувьд программ хангамжийн лиценз, техник хангамжийн тоног төхөөрөмжийг шууд худалдан авах хэрэгцээ шаардлага гардаг онцлог байгууллага юм.

## ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

*Зорилт 1. Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын талаар*

Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүрэг:

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/34 тоот тушаалаар 12 зүйл заалт бүхий дүрмийг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын эрхэм зорилгын хүрээнд Монгол Улсын цахим үйлчилгээний дэд бүтэц, суурь хөгжлийг бэхжүүлэхээр ажиллаж байна. Үндэсний дата төв нь дараах төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж төсвийн орлогыг бүрдүүлдэг байна. Үүнд:

1. Төрийн байгууллагын домэйн нэр олгох
2. Төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох
3. Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах
4. Төрийн байгууллагын зохиомол сервер түрээслэх
5. Зогсуур түрээсийн үйлчилгээ
6. Мэдээллийн санг байршуулах
7. Мэдээлэл солилцооны системд холбох
8. Танилт, нэвтрэлтийн систем холбох
9. Төрийн үйлчилгээний цахим машины үйлчилгээ
10. Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ
11. Мэдэгдэл хүргэх систем

Тушаал, шийдвэрийн талаар:

“Үндэсний дата төв” УТҮГ-нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуустал хүний нөөцтэй холбоотой Б тушаал 136, үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 113 бүртгэгдэж, төвийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм, Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, Архив, албан хэрэг хөтлөлтийн журам, мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC:2017 стандарттай холбоотой Эмзэг байдлын удирдлагын журам, Биет байдал болон орчны аюулгүй байдлын журам, Үйл ажиллагааны аюулгүй байдлын журам, чанарын удирдлагын тогтолцоо олон улсын ISO9001:2015 стандарттай холбоотой Үл тохирол ба залруулга, залруулах, урьдчилан сэргийлэх журам, Чанарын удирдлагын тогтолцооны дотоод аудитын журам, Удирдлагын дүн шинжилгээний хурал зохион байгуулах журмуудыг тус тус баталсан байна.

Урсгал худалдан авалт:

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд Үндэсний дата төвийн тоног төхөөрөмж, техникийн хүчин чадлыг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Үндэсний дата төв хариуцан ажилласан.

Нийт 11,791,369,998.50 төгрөг батлагдсан бөгөөд 11,164,227,297.6 төгрөгийн худалдан авалт хийгдсэн байна.



Урсгал зардлаас гэрээ байгуулсан ажлын жагсаалт

/төгрөгөөр/

| №   | Худалдан авах бараа,ажил үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал     | ХАА -ны батлагдсан нийт өртөг | Гэрээ байгуулагдсан компанийн нэр | Гэрээ байгуулагдсан дүн | Төлбөр шилжигдсэн    |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|-----------------------------------|-------------------------|----------------------|
|     | <b>2024 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА</b>                                                                | <b>11,811,369,999</b>         |                                   | <b>11,111,607,298</b>   |                      |
| 1.1 | <b>Мэдээллийн технологи, программ хангамжийн лиценз</b>                                                | <b>6,311,542,244</b>          |                                   | <b>6,032,048,025</b>    |                      |
| 1   | Сүлжээний аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн программ хангамжийн сунгалтын лиценз нийлүүлэх            | 1,515,636,900                 | Вертексмон ХХК                    | 1,514,997,990           | 1,439,248,091        |
| 2   | Мэдээллийн аюулгүй байдлын программ хангамжийн сунгалтын лиценз нийлүүлэх                              | 1,119,425,600                 | Вертексмон ХХК                    | 1,118,396,400           | 1,062,476,580        |
| 3   | Цахим системийн эмзэг байдал шалгах программ хангамжуудын сунгалтын лиценз нийлүүлэх                   | 359,670,000                   | Ай нэт про ХХК                    | 359,570,000             | 341,591,500          |
| 4   | Мэдээллийн сангийн төхөөрөмжийн дэмжлэг тусалцаа, өгөгдлийн сангийн лиценз нийлүүлэх                   | 630,000,000                   | Ай ти зон ХХК                     | 619,661,606             | 619,661,606          |
| 5   | Нэгдмэл дэд бүтцийн төхөөрөмжийн баталгаат хугацаа, дэмжлэг тусалцааны сунгалтын лиценз нийлүүлэх      | 668,935,504                   | Ай ти зон ХХК                     | 654,449,290             | 654,449,290          |
| 6   | Хадгалах төхөөрөмжийн баталгаат хугацаа, дэмжлэг тусалцааны сунгалтын лиценз нийлүүлэх                 | 672,710,000                   | Саммит компьютер технологи ХХК    | 668,439,640             | 648,386,450          |
| 7   | Төрийн клауд системийн, программ хангамжийн лиценз нийлүүлэх                                           | 480,000,000                   | Фибо глобал ХХК                   | 480,000,000             | 480,000,000          |
| 8   | Хадгалах төхөөрөмж болон сервер тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл нийлүүлэх                           | 145,966,720                   | Саммит компьютер технологи ХХК    | 143,130,000             | 135,973,500          |
| 9   | Удирдлагын нэгдсэн системийн программ хангамжийн лиценз нийлүүлэх                                      | 96,000,000                    | Ай ти инсайт ХХК                  | 95,500,000              | 95,500,000           |
| 10  | Цахим хуудасны удирдлагын системийн лиценз нийлүүлэх                                                   | 69,973,650                    | Софт солюшн ХХК                   | 69,828,000              | 69,828,000           |
| 11  | Оффисын программ хангамжийн лиценз нийлүүлэх                                                           | 57,200,000                    | Могул сервис ХХК                  | 39,110,160              | 39,110,160           |
| 12  | Хэрэглээний программ хангамжийн лиценз нийлүүлэх                                                       | 50,473,870                    | Ти энд ти про ХХК                 | 50,448,794              | 50,448,794           |
| 13  | Хяналтын болон дата анализ хийх программ хангамжийн лиценз нийлүүлэх                                   | 106,468,000                   | Ай ти зон ХХК                     | 104,951,440             | 104,951,440          |
| 14  | Серверийн тусгай орчныг бүрдүүлэхэд шаардлагатай техникийн сэлбэг хэрэгсэл                             | 134,700,000                   | Ижил орд ХХК                      | 129,669,500             | 123,186,025          |
| 15  | Сургалтын онлайн платформын эрх нийлүүлэх                                                              | 38,000,000                    | Инносолушн ХХК                    | 37,620,000              | 37,620,000           |
| 16  | MN домэйн нэрийн сунгалт                                                                               | 1,452,000                     |                                   | 1,452,000               | 1,452,000            |
| 17  | Цахим хуудасны SSL сертификат нийлүүлэх                                                                | 17,430,000                    | Сайбервэйр ХХК                    | 18,524,400              | 18,524,400           |
| 18  | Төслийн удирдлагын программ хангамжийн лиценз нийлүүлэх                                                | 19,800,000                    | Эй ти си жи ХХК                   | 19,888,189              | 19,888,189           |
| 19  | Гадаад хаягийн сунгалт                                                                                 | 9,900,000                     |                                   | 9,900,000               | 9,900,000            |
| 20  | IP хаягийн сунгалт                                                                                     | 3,800,000                     |                                   | 3,800,000               | 3,800,000            |
| 21  | Өгөгдлийн сангийн программ хангамжийн лиценз                                                           | 15,000,000                    | Хамтдаа солюшн ХХК                | 15,000,000              | 15,000,000           |
| 22  | Мэдээллийн сангийн төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл                                                        | 11,000,000                    | Кодинг системс ХХК                | 11,000,000              | 11,000,000           |
| 23  | Утасгүй сүлжээний тоноглол, сэлбэг хэрэгсэл                                                            | 68,000,000                    | Ай нэт про ХХК                    | 67,672,000              | 67,672,000           |
| 24  | Сүлжээний архитектур шийдэл зохион байгуулах, сайжруулах                                               | 20,000,000                    | Софт пос ХХК                      | 20,000,000              | 20,000,000           |
| 1.2 | <b>Цахим шилжилт арга хэмжээ</b>                                                                       | <b>4,296,184,000</b>          |                                   |                         | <b>4,084,636,782</b> |
| 25  | Төрийн клауд системийн суурь дэд бүтцийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах             | 530,000,000                   | Тонхил хайрхан ХХК                | 529,300,000             | 502,835,000          |
| 26  | Сүлжээний халдлагыг илрүүлэх хариу үзүүлэх систем, программ хангамжийн лиценз нийлүүлэх                | 416,000,000                   | Вертексмон ХХК                    | 415,944,100             | 415,944,100          |
| 27  | Төрийн клауд системийн суурь дэд бүтцийн хөргөлтийн төхөөрөмжийн шинэчлэлт сайжруулалт хийх            | 460,000,000                   | Синус Дочи ХХК                    | 457,163,455             | 434,305,282          |
| 28  | Төрийн клауд системийн Б блокийн хөргөлтийн системийн сайжруулалт хийх                                 | 222,184,000                   | Алхими ХХК                        | 220,792,000             | 209,752,400          |
| 29  | Серверийн хэсгийн албадмал агаарын хөргөлтийн сэлбэг хэрэгсэл                                          | 68,000,000                    | Гэрэлт бат цамхаг ХХК             | 67,800,000              | 67,800,000           |
| 30  | Орон нутгийн салбар төв болон ТҮЦ машины ашиглалт үйлчилгээнд ашиглах бага оврын автобус худалдан авах | 100,000,000                   | ЭМНМ ХХК                          | 98,000,000              | 98,000,000           |



|            |                                                                                                                                                   |                    |                                  |               |                    |
|------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----------------------------------|---------------|--------------------|
| 31         | Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх /КИОСК/                                                                                         | 2,500,000,000      | Гэрэгэ киоск ХХК                 | 2,480,000,000 | 2,356,000,000      |
| <b>1.3</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ</b>                                                                                        | <b>424,960,955</b> |                                  |               | <b>310,068,955</b> |
| 32         | Хяналт, мониторингийн зөвлөх үйлчилгээ                                                                                                            | 58,750,000         | Ай ти инсайт ХХК                 | 58,600,000    | 58,600,000         |
| 33         | Гамшгийн үеийн эрсдэлийг тодорхойлох үйлчилгээ                                                                                                    | 35,000,000         | Дат консалтинг ХХК               | 32,850,000    | 32,850,000         |
| 34         | Дата төвийн стандарт, салбарын мэдээллийн технологийн чиг хандлагад суурилсан судалгаа, шинжилгээ хийх, бодлого, төлөвлөлт боловсруулах үйлчилгээ | 18,000,000         | Өмгөөллийн Золо энд партнерс ХХК | 9,800,000     | 9,800,000          |
| 35         | МАБУТ 27001 магадлах аудит                                                                                                                        | 16,842,000         | Монсерфт ХХК                     | 16,800,000    | 16,800,000         |
| 36         | МАБУТ 27001 магадлах аудитын бэлтгэл ажил хангах                                                                                                  | 8,000,000          | Майнд маркет консалтинг          | 8,000,000     | 8,000,000          |
| 37         | QMS ISO9001 аудит                                                                                                                                 | 9,000,000          | Эф эм си ХХК                     | 9,000,000     | 9,000,000          |
| 38         | QMS ISO9001 бэлтгэл ажил хангах, баримт бичгийн боловсруулалт                                                                                     | 12,000,000         | Ай Эм Си Эй ХХК                  | 12,000,000    | 12,000,000         |
| 39         | Архивын сан хөмрөг үүсгэх, архивын баримт бичигт эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажил гүйцэтгэх                                           | 15,000,000         | Батбилэг Бат-Очир                | 15,000,000    | 15,000,000         |
| 40         | Гэрээт ажил, үйлчилгээ /дизайн/                                                                                                                   | 15,000,000         | Гарүна Интернейшнл ХХК           | 15,000,000    | 15,000,000         |
| 41         | Мэдээллийн технологийн ажил, үйлчилгээ хийж гүйцэтгүүлэх                                                                                          | 43,312,500         |                                  | 43,312,500    | 43,312,500         |
| 42         | Нөөц серверийн өрөөний тааз засварын ажил гүйцэтгүүлэх                                                                                            | 17,010,455         | Сажитарус ХХК                    | 17,010,455    | 17,010,455         |
| 43         | Байгууллагын дотоод үйл ажиллагааны оновчлол, процессын автоматжуулалт нэвтрүүлэх                                                                 | 19,800,000         | Цэгц солюшн ХХК                  | 19,700,000    | 19,700,000         |
| 44         | Мэдээллийн аюулгүй байдлын дэмжлэг туслалцаа                                                                                                      | 19,500,000         | Цэцпрогресс ХХК                  | 19,500,000    | 19,500,000         |
| 45         | Реле хамгаалалтын төхөөрөмжийг суурилуулах, тохируулга хийх, ашиглалтанд оруулах ажил                                                             | 10,650,000         | Мега бүүстер ХХК                 | 10,650,000    | 10,650,000         |
| 46         | Дата төвд шаардлагатай тоног төхөөрөмж болон нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон статистик судалгаа гаргах үйлчилгээ                         | 20,000,000         | -                                | -             | -                  |
| 47         | Хэрэглэгчийн үйлчилгээний цахим системийн UI, UX дизайн боловсруулах                                                                              | 19,000,000         | Цэгц солюшн ХХК                  | 12,200,000    | 12,200,000         |
| 48         | Мэдээллийн сангийн системийн ашиглалт үйлчилгээний өртгийг бууруулах судалгаа хийх шийдэл боловсруулах                                            | 45,000,000         | -                                | -             | -                  |
| 49         | Мэдээллийн ил тод байдлыг хангах байгууллагын танилцуулга хуудас шинэчлэх                                                                         | 17,450,000         | -                                | -             | -                  |
| 50         | Ажилчдын автобус ашиглалтын үйлчилгээний түрээс                                                                                                   | 15,246,000         | Мустангар ХХК                    | 15,246,000    | 15,246,000         |
| 51         | Бусад түрээсийн зардал                                                                                                                            | 10,400,000         |                                  | 10,400,000    | 10,400,000         |
| <b>1.4</b> | <b>Улсын мэдээллийн маягт бэлтгэх</b>                                                                                                             | <b>98,590,500</b>  |                                  |               | <b>77,400,000</b>  |
| 52         | ТҮЦ машины бичгийн цаас, принтерийн хор бул нийлүүлэх                                                                                             | 98,590,500         | Төгс дардас ХХК                  | 77,400,000    | 77,400,000         |
| <b>1.5</b> | <b>Түлш халаалт, тээвэр шатахууны зардал</b>                                                                                                      | <b>72,819,800</b>  |                                  |               | <b>52,550,000</b>  |
| 53         | Түлш, шатахуун нийлүүлэх                                                                                                                          | 72,819,800         | Сод монгол ХХК                   | 70,561,000    | 52,550,000         |
| <b>1.6</b> | <b>Урсгал зардал, багаж хэрэгсэл</b>                                                                                                              | <b>340,800,000</b> |                                  |               | <b>328,773,776</b> |
| 54         | Төрийн үйлчилгээний цахим машины ашиглалт үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нийлүүлэх                                     | 20,000,000         | Стар энерги сервис ХХК           | 19,250,000    | 19,250,000         |
| 55         | Сүлжээний сэлбэг хэрэгсэл                                                                                                                         | 18,000,000         | Софт солюшн ХХК                  | 17,820,000    | 17,820,000         |
| 56         | Физик серверийн санах ой                                                                                                                          | 14,500,000         | Оп ти мум си эс ХХК              | 16,560,000    | 16,560,000         |
| 57         | Өгөгдлийн сангийн дэд бүтцийн сэлбэг хэрэгсэл                                                                                                     | 19,000,000         | Кодинг системс ХХК               | 17,818,078    | 17,818,078         |
| 58         | Аюулгүй байдлын сэлбэг хэрэгсэл                                                                                                                   | 6,800,000          |                                  | 6,800,000     | 6,800,000          |
| 59         | Цахилгаан хангамжийн системийн сэлбэг хэрэгсэл                                                                                                    | 19,000,000         | Натурал монголиа индустри ХХК    | 18,700,000    | 18,700,000         |
| 60         | Автомашины сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ                                                                                                      | 8,000,000          |                                  | 8,000,000     | 8,000,000          |
| 61         | Хөргөлтийн системийн сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ                                                                                            | 13,000,000         |                                  | 13,000,000    | 13,000,000         |



|     |                                                                    |                    |                            |             |                    |
|-----|--------------------------------------------------------------------|--------------------|----------------------------|-------------|--------------------|
| 62  | Барилга байгууламжийн урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх         | 140,000,000        | Энх тэргүүн констракшн ХХК | 135,079,682 | 128,325,698        |
| 63  | Техникийн сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ                        | 42,500,000         |                            | 42,500,000  | 42,500,000         |
| 64  | Бусад сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ                            | 40,000,000         |                            | 40,000,000  | 40,000,000         |
| 1.7 | <b>Бичиг хэргийн зардал</b>                                        | <b>46,472,500</b>  |                            |             | <b>44,322,210</b>  |
| 65  | Бичиг хэргийн зардал                                               | 46,472,500         |                            | 44,322,210  | 44,322,210         |
| 1.8 | <b>Хөдөлмөр хамгаалал</b>                                          | <b>4,000,000</b>   |                            |             | <b>2,291,350</b>   |
| 66  | Хөдөлмөр хамгааллын багаж болон хувцас, аж ахуйн материал хэрэгсэл | 4,000,000          |                            | 2,291,350   | 2,291,350          |
| 1.9 | <b>Тавилга, эд хогшил</b>                                          | <b>33,000,000</b>  |                            |             | <b>32,820,200</b>  |
| 67  | Тавилга, эд хогшил                                                 | 33,000,000         |                            | 32,820,200  | 32,820,200         |
| 2.1 | <b>Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого</b>                        | <b>183,000,000</b> |                            |             | <b>146,696,000</b> |
| 68  | Тавилга эд хогшил                                                  | 85,000,000         |                            | 48,696,000  | 48,696,000         |
| 69  | Тээврийн хэрэгсэл                                                  | 98,000,000         | ЭМНМ ХХК                   | 98,000,000  | 98,000,000         |

Төлөвлөгөө тайлангийн хэрэгжилт:

2024 онд 4 стратеги 14 зорилтын хүрээнд ажилласан. Гүйцэтгэлийн тайлангийн нийт үзүүлэлт 150 ажил үйлчилгээг 99.5%-тай хийж гүйцэтгэсэн.

|                                                                                                    |                                                                                                                                                                                  |
|----------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>СТРАТЕГИ I</b><br>Байгууллагын хэвийн найдвартай ажиллагааг хангах, суурь дэд бүтцийг хөгжүүлэх | Зорилт 1 - Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх                                                                                                                 |
|                                                                                                    | Зорилт 2 - Хамтын ажиллагааг хөгжүүлэх                                                                                                                                           |
|                                                                                                    | Зорилт 3 - Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах                                                                                                                                  |
|                                                                                                    | Зорилт 4 - Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах                                                                                                                            |
|                                                                                                    | <b>ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ – 81</b>                                                                                                                                                     |
|                                                                                                    | <b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ – 99.9%</b>                                                                                                                                                 |
| <b>СТРАТЕГИ II</b><br>Төрийн мэдээллийн санг байршуулах, нэгтгэх, хадгалах                         | Зорилт 1 - Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх, таатай нөхцөл бүрдүүлэхэд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай судалгаа хийж, санал боловсруулах |
|                                                                                                    | Зорилт 2 - Төрийн байгууллагуудын мэдээллийн санг нэгтгэх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх                                                                                   |
|                                                                                                    | <b>ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ – 11</b>                                                                                                                                                     |
|                                                                                                    | <b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ – 100%</b>                                                                                                                                                  |
| <b>СТРАТЕГИ III</b><br>Мэдээллийн аюулгүй байдлыг хангах                                           | Зорилт 1 - Систем, сүлжээ болон орчны аюулгүй байдлыг хангах                                                                                                                     |
|                                                                                                    | Зорилт 2 - Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах                                                                                                                      |
|                                                                                                    | Зорилт 3 - Халдлагад хариу үйлдэл үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын зөвлөгөө өгөх                                                                                              |
|                                                                                                    | <b>ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ – 31</b>                                                                                                                                                     |
|                                                                                                    | <b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ – 100%</b>                                                                                                                                                  |
| <b>СТРАТЕГИ IV</b><br>Мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ үзүүлэх                            | Зорилт 1 - Төрийн мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх                                                                                                                          |
|                                                                                                    | Зорилт 2 - Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх                                                                                                       |
|                                                                                                    | Зорилт 3 - Төрийн байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу мэдээллийн үйлчилгээгээр хангах                                                                      |
|                                                                                                    | Зорилт 4 - Монголын интернэтийн харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх                                                                                                             |
|                                                                                                    | Зорилт 5 - Контентын харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх                                                                                                                        |
|                                                                                                    | <b>ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ – 27</b>                                                                                                                                                     |
|                                                                                                    | <b>ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ – 98%</b>                                                                                                                                                   |



## Дотоод хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн талаар:

### Тушаал шийдвэртэй холбоотой илэрсэн зөрчлийн талаар:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.2.3-т "Хууль тогтоомж, өөрөөр заагаагүй бол үндэслэл хэсэгт уг баримт бичгийг зохион бүрдүүлэх хууль зүйн үндэслэл, шалтгаан, зориулалт, зорилгыг тодорхой бичнэ" гэж заасныг мөрдөөгүй.
  - "Хүний нөөцтэй холбоотой 2024 оны Б/43, Б/48, Б/49, Б/50, Б/51, Б/52, Б/53, Б/54, Б/55, Б/56, Б/57, Б/58, Б/59, Б/60, Б/61, Б/62, Б/63, Б/64, Б/65, Б/66, Б/67, Б/68, Б/69, Б/70, Б/71, Б/72, Б/73, Б/74, Б/75, Б/76, Б/77, Б/78, Б/79, Б/80, Б/81, Б/82, Б/83 тоот тушаалуудад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4/ "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" 20 дугаар зүйлийн 20.10. "эрх хэмжээний асуудлаар хууль, тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах" гэсэн зохицуулалтыг үндэслэсэн. Энэхүү хуулийн зохицуулалт нь Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын эрх үүрэг болон холбогдох харилцааг зохицуулдаг бөгөөд тус төвийн үйл ажиллагаанд хамаарахгүй хуулийн зохицуулалт юм.
2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.2.4.3-т " .... албан тушаалтны нэрийг ( ) хаалтад бичих гэж заасныг мөрдөөгүй:
  - Б/51, Б/52, Б/56, Б/57, Б/58, Б/62, Б/63, Б/65, Б/66, Б/67, Б/68, Б/70, Б/71, Б/73, Б/74, Б/75, Б/76, Б/78, А/56, А/57, А/59, А/61, А/63, А/65, А/66, А/67 тоот тушаалуудад албан тушаалтны нэрийг ( ) бичихгүйгээр албан тушаалыг ( ) бичсэн байна.
3. Сургалтад хамруулах Б/27, Б/67, тухай тушаалууд дээр Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.12.5.4-т заасан "Эрхэлж буй албан тушаалын хэрэгцээ шаардлагыг харгалзан Байгууллагын зардлаар болон бусад төсөл, хөтөлбөрийн хүрээнд гадаад дотоодын их, дээд сургууль, коллеж, сургалтын төвд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах үедээ гэрээ байгуулан цалинтай чөлөө олгож болох ба энэ тохиолдолд сургалтын гэрээ байгуулж, сургалтад хамрагдсан ажилтан сургалтаа дуусгаж буцаж ирснээс хойш 6 сараас 1 жил хүртэлх хугацаагаар тогтвортой ажиллах ба уг хугацааг дуусгалгүй ажлаас гарах тохиолдолд зардлыг ажилтнаас гаргуулж болно" гэсэн заалтын дагуу ажилтантай сургалтын гэрээ хийх талаар тушаалд тусгаагүй байна.

### Хүний нөөцтэй холбоотой асуудлаар

Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдын 2024 оны А/04 тоот "Үндэсний дата төв" УТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай тушаалаар 4 газар 2 хэлтэс 1 төвтэй нийт 86 ажилтантай байхаар тогтоосон. Тус төв нь 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 65 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Нийт 65 ажилтны тус бүрийн хувийн хэрэгтэй танилцахад дараах баримт бичиг дутуу бүрдүүлсэн байна. Үүнд:

Төвийн захирлын 2024 оны А/93 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.2.5-д Захиргаа, удирдлагын газар нь ажилдаа авахдаа дараах



баримт бичгийг бүрдүүлэн Хувийн хэрэгт авна. Үүнд: ерөнхий боловсролын сургууль, дээд сургууль, их сургууль төгссөн гэрчилгээ, дипломын хуулбар, мэргэжлийн сертификатын хуулбар, гэр бүлийн гурван үеийн товч намтар, төрийн албан хаагчийн анкет гэж заасан.

Журамд заасан холбогдох баримт бичиг дутуу:

1. Хэрэглэгчийн үйлчилгээний хэлтсийн Гэрээ хариуцсан мэргэжилтэн М.Саруул-Одын дипломын хуулбар болон гэр бүлийн гурван үеийн намтар дутуу.
2. Мэдээллийн технологийн газрын DevOps инженер Ц.Цэрэнпунцагийн дипломын хуулбар дутуу.

#### ДҮГНЭЛТ:

Үндэсний Дата төв УТҮГ нь дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж ажиллаж, удирдлага, санхүүгийн ажилтнууд нь 2024 оны санхүүгийн байдал, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээ бусад тодруулгыг холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, эрх зүйн актын дагуу тайлагнасан байна.

Дотоод хяналт шалгалтаар тус байгууллага "Зөрчилгүй" гэсэн дүгнэлтийг өгч байна.

#### Цаашид анхаарч ажиллах талаар:

- Тушаал шийдвэр боловсруулахдаа үндэслэл хэсгийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамтай нийцүүлдэг байх.
- Ажилтантай холбоотой санал хүсэлтэд хүлээн авч түүнтэй холбоотой тушаал гаргаж буй тохиолдолд тухайн санал хүсэлтийг тушаалын ард хавсарган хадгалдаг байх
- Ажилтны хувийн хэргийг бүрдүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах;

#### ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙПАНГ

##### **БЭЛТГЭСЭН:**

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.УРАНГУА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ХУУЛЬЧ



Г.АНАР

##### **ХЯНАСАН:**


ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА



Х.ТӨРИЙНЖАВХЛАН

##### **ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:**

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
"ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ" УТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ



Д.СЭЛЭНГЭ

М.БАТТУЛГА